

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Аудитор Ч.Даваасүрэн	
	Утас: 99559722	Цахим хаяг: daavkach@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЕСӨНБУЛАГ СУМЫН 9 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ХИШИГБАЯР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.01.25 № 83

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020100

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,576,059.22	31,516,915.85
33	АВЛАГА	-	114,356.63
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	114,356.63
35	БАРАА МАТЕРИАЛ	10,576,059.22	31,402,559.22
351	Түүхий эд материал	3,323,559.22	8,173,559.22
35110	Тусгай зориулалттай материал	3,323,559.22	8,173,559.22
354	Хангамжийн материал	7,252,500.00	23,229,000.00
35420	Аж ахуйн материал	7,252,500.00	23,229,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	38,955,783.46	75,578,610.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	38,955,783.46	75,578,610.98
392	Биет хөрөнгө	38,955,783.46	75,578,610.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,693,500.00	42,627,050.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,991,816.62)	(6,825,516.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,275,600.00	37,949,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,946,499.92)	(6,197,022.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,000,000.00	9,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(675,000.00)	(1,575,000.00)
39217	Ном	600,000.00	600,000.00
39301	Програм хангамж	255,000.00	255,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(255,000.00)	(255,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	49,531,842.68	107,095,526.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	49,531,842.68	107,095,526.83
51	Засгийн газрын хувь оролцоо	49,531,842.68	107,095,526.83
512	Хуримтлагдсан үр дүн	49,531,842.68	107,095,526.83
51210	Өмнөх үеийн үр дүн	21,072,550.13	49,531,842.68
51220	Тайлант үеийн үр дүн	28,459,292.55	57,563,684.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	49,531,842.68	107,095,526.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	345,548,686.00	396,880,100.00
12.00	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	437,000.00
120.00	Нийтлэг татварын бус орлого	-	437,000.00
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	437,000.00
1,200,045.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	437,000.00
120,017.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		437,000.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	345,548,686.00	396,443,100.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	290,920,600.00	354,669,200.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	290,920,600.00	354,669,200.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,829,486.00	-
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,829,486.00	
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,798,600.00	41,773,900.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,798,600.00	41,773,900.00
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	322,337,893.45	339,316,415.85
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	322,337,893.45	339,316,415.85
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,894,503.70	334,809,817.66
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,628,507.79	232,302,561.77
210,101.00	Үндсэн цалин	188,709,458.69	211,542,613.81
210,104.00	Урамшуулал	19,919,049.10	20,759,947.96
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,380,625.34	30,820,954.58
210,201.00	Тэтгэврийн даатгал	20,100,218.34	21,565,724.94
210,202.00	Тэтгэмжийн даатгал	60,292.00	2,291,693.46
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,610,223.00	1,872,608.98
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	417,452.00	462,811.49
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,192,440.00	4,628,115.71
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,936,188.12	28,659,356.08
210,301.00	Гэрэл, цажилгаан	2,235,560.12	2,351,060.17
210,302.00	Түлш, халаалт	27,238,024.00	24,750,663.91
210,303.00	Цэвэр, божир ус	1,462,604.00	1,557,632.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	2,494,950.00	3,888,697.75
210,401.00	Бичиг хэрэг	400,000.00	400,000.00
210,402.00	Тээвэр, шатахуун	240,000.00	223,200.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	599,750.00	648,797.75
210,404.00	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, жортон мэрэгчдийн устгал, ариутгал	304,000.00	260,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	851,200.00	2,256,700.00
2,105.00	Нормативт зардал	19,023,935.00	17,013,175.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	365,000.00	749,600.00
210,502.00	Хоол, хүнс	18,658,935.00	16,263,575.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	10,499,500.00	13,076,900.00
210,604.00	Урсгал засвар	10,499,500.00	13,076,900.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	957,400.00	1,427,500.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	779,500.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	4,973,397.45	7,620,672.48
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	770,000.00	636,450.00
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,203,397.45	6,984,222.48
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,443,389.75	4,506,598.19
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	10,257,786.00	1,598,400.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,428,300.00	1,598,400.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,362,911.88	37,643.92
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,362,911.88	37,643.92
2,135.00	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,822,691.87	2,870,554.27
213,503.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,822,691.87	2,870,554.27
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,210,792.55	57,563,684.15
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	23,210,792.55	57,563,684.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулс	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	49,531,842.68	-	49,531,842.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	49,531,842.68	-	49,531,842.68
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	49,531,842.68	-	49,531,842.68
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	49,531,842.68	-	49,531,842.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	49,531,842.68	-	49,531,842.68
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	57,563,684.15	-	57,563,684.15
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	107,095,526.83	-	107,095,526.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	345,548,686.00	396,443,100.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	345,548,686.00	396,443,100.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	290,920,600.00	354,669,200.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	290,920,600.00	354,669,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,829,486.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчийн урваарилсан хөрөнгө	8,829,486.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,798,600.00	41,773,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,798,600.00	41,773,900.00
2.00	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	321,268,686.00	352,836,050.00
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	321,268,686.00	352,836,050.00
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,825,296.25	348,329,451.81
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,628,507.79	232,302,566.25
210,101.00	Үндсэн цалин	188,709,458.69	211,542,618.28
210,104.00	Урамшуулал	19,919,049.10	20,759,947.97
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,380,625.34	30,935,306.73
210,201.00	Тэтгэврийн даатгал	20,100,218.34	21,649,228.39
210,202.00	Тэтгэмжийн даатгал	60,292.00	2,296,042.43
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,610,223.00	1,881,541.86
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	417,452.00	463,954.45
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,192,440.00	4,644,539.60
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,936,188.12	28,659,356.08
210,301.00	Гэрэл, цахилгаан	2,235,560.12	2,351,060.17
210,302.00	Түлш, халаалт	27,238,024.00	24,750,663.91
210,303.00	Цэвэр, бохир ус	1,462,604.00	1,557,632.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	2,494,950.00	3,451,697.75
210,401.00	Бичиг хэрэг	400,000.00	400,000.00
210,402.00	Тээвэр, шатахуун	240,000.00	223,200.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	599,750.00	648,797.75
210,404.00	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	304,000.00	260,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	851,200.00	1,819,700.00
2,105.00	Нормативт зардал	20,058,125.00	30,763,175.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	365,000.00	749,600.00
210,502.00	Хоол, хүнс	17,153,125.00	16,263,575.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,540,000.00	13,750,000.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	12,599,500.00	15,303,400.00
210,602.00	Тавилга	2,100,000.00	2,226,500.00
210,604.00	Урсгал засвар	10,499,500.00	13,076,900.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	957,400.00	1,427,500.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	-	779,500.00
210,802.00	хураамж Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	770,000.00	5,486,450.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	770,000.00	5,486,450.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,443,389.75	4,506,598.19
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	10,257,786.00	1,598,400.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,428,300.00	1,598,400.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,362,911.88	37,643.92
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,362,911.88	37,643.92
2,135.00	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,822,691.87	2,870,554.27
213,503.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,822,691.87	2,870,554.27
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,280,000.00	43,607,050.00
5.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,280,000.00	43,607,050.00
22.00	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,280,000.00	43,607,050.00
2,200.00	Дотоод эх үүсвэрээр	24,280,000.00	43,607,050.00
225,106.00	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,280,000.00	43,607,050.00
6.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(24,280,000.00)	(43,607,050.00)



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2.00	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	396,443,100.00	393,534,901.81
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	396,443,100.00	393,534,901.81
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,843,100.00	391,936,501.81
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,535,000.00	232,302,566.25
210,101.00	Үндсэн цалин	212,480,000.00	211,542,618.28
210,104.00	Урамшуулал	21,055,000.00	20,759,947.97
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,790,000.00	30,935,306.73
210,201.00	Тэтгэврийн даатгал	22,222,000.00	21,649,228.39
210,202.00	Тэтгэмжийн даатгал	2,392,000.00	2,296,042.43
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,913,000.00	1,881,541.86
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	480,000.00	463,954.45
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,783,000.00	4,644,539.60
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,697,000.00	28,659,356.08
210,301.00	Гэрэл, цахилгаан	2,550,000.00	2,351,060.17
210,302.00	Түлш, халаалт	24,612,000.00	24,750,663.91
210,303.00	Цэвэр, бохир ус	1,535,000.00	1,557,632.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	3,480,000.00	3,451,697.75
210,401.00	Бичиг хэрэг	400,000.00	400,000.00
210,402.00	Тээвэр, шатахуун	240,000.00	223,200.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	660,000.00	648,797.75
210,404.00	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	260,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,820,000.00	1,819,700.00
2,105.00	Нормативт зардал	31,416,700.00	30,763,175.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	750,000.00	749,600.00
210,502.00	Хоол, хүнс	16,916,700.00	16,263,575.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,750,000.00	13,750,000.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	52,876,900.00	52,876,900.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	19,900,000.00	19,900,000.00
210,602.00	Тавилга	19,900,000.00	19,900,000.00
210,604.00	Урсгал засвар	13,076,900.00	13,076,900.00
2,107.00	Томилолт, зочны зардал	100,000.00	-
210,702.00	Дотоод албан томилолт	100,000.00	
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,427,500.00	1,427,500.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	779,500.00	779,500.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	11,520,000.00	11,520,000.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,520,000.00	11,520,000.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,600,000.00	1,598,400.00
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	1,598,400.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,598,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	396,443,100.00	393,534,901.81
1,310.00	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	354,669,200.00	351,798,645.73
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,669,200.00	351,798,645.73
1,320.00	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,773,900.00	41,736,256.08
132,001.00	Орон нутгийн төсвөөс	41,773,900.00	41,736,256.08

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудиторын туслах Ч.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдарын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлийг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 350.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 396.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр тогтоогдлоо.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 114.6 хувиар буюу 56.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31.4 сая төгрөг болж 20.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 54.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 16.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 34.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 89.6 сая төгрөг болж 42.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 42.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 106.3 сая төгрөг болж 56.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 13.0 хувиар буюу 45.6 сая төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 56.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 262.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 133.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 396.4 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 396.4 сая төгрөгийн төсөв баталснаас 354.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 41.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 354.6 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 41.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 393.5 сая төгрөгийг зарцуулж 2.8 сая төгрөгийг улсын төсөвт, 0,03 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 393.5 сая төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 1.2 сая төгрөгөөр, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 0.8 сая төгрөгөөр, нормативт зардлыг 0.7 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 0.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.03 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

ТОДОРХОЙЛСОН ТАЙЛАНТ ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ҮЛЭМЖ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛУУД БАЙХГҮЙ БОЛНО.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 810.1 сая төгрөгийн 132 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод мэдээлэхээс

хугацаандаа мэдээлсэн 810.1 сая төгрөгийн 132 мэдээлэл оруулсанаас 354.8 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4.1 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ, АНХААРАЛ ТАТАХУЙЦ АСУУДАЛ

Дараа жилийн аудитаар

- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал
- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх
- Цэцэрлэгийн халаалтын талбайн хэмжээг тодорхойлж бодитой эсэхийг шалгах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх

Анхаарал татахуйц асуудал

- Худалдаж авсан зарим хөрөнгө болох зөөврийн компьютер, өсгөгч фульт, 32 инчийн телевиз, 2-р хоолны тогоо зэрэг хөрөнгүүд бусад байгууллагуудтай болон зах зээлийн мэдээлэлтэй харьцуулахад өндөр үнэтэй авсан байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.8 сая төгрөгт албан шаардлага, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчил илэрч албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

- ✓ Улирлын үр дүнгийн урамшууллыг тушаал шийдвэрээс зөрүүтэй 1.1 сая төгрөг дутуу, 0.1 сая төгрөг илүү олгосон нь “Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

- ✓ Ажилтны амралт, цалин давхардуулан 0.1 сая төгрөг олгосон нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Есөнбулаг сумын 8-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 06 сарын 18-ны А/13 тоот "Ээлжийн амралт олгох тухай" тушаал"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- ✓ Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 0.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.2 Албан шаардлага

- ✓ Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 2.8 сая төгрөгийн тавилга, эд хогшлийн худалдан авалт хийсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт" ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой , зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс , арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож , урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 354.9 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр " гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 9 дүгээр цэцэрлэг	5	4.3	-	-	2	1.5	2	2.8	1	